1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,433,200.00	2,483,848.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,272,800.00	2,483,848.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	160,400.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,804,712.92	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	133,767,224.05	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-
620001	Удирдах ажилтан		
620002	Гүйцэтгэх ажилтан		
620003	Үйлчлэх ажилтан		
620004	Гэрээт ажилтан		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		
650010	Гэрээт ажилтан		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

байхгүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь бага дунд боловсрол олгох чиг үүрэг бүхий байгууллага.

Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн тайлант оны зорилгыг “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулах, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах “ гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузел суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Сургуулийн 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2023 оны 10 сарын 23-ны өдрийн А/29 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.9 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30,804.70	133,767.20	-102,962.5
Авлага	1,530.00	-	1530.00
Урьдчилгаа	-	20,470.00	
Бараа материал	153,255.10	149,691.80	-373.4
Үндсэн хөрөнгө	4,086,311.90	4,036,691.80	-17,841.90
Нийт хөрөнгө	4,271,901.70	4,340,620.80	-17,931.20
Өр төлбөр	11005.9	6932.3	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,260,895.80	4,333,688.50	-17,931.20
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,271,901.70	4,340,620.80	-17,931.20

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө оны эцэст 133.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 102.9 сая төгрөгөөр өссөн байна.Зарцуулагдаагүй төсвийн дийлэнх үлдэгдлийг цалингийн зардал болон хоолны зардал эзэлж байна.Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 0.02 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Оны эхэнд байсан мэдээлэл технологийн зардлаас авах /Юнитель/ 1.5 сая төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын үлдэгдэл 0.4 сая төгрөгөөр буурсан байна.Төсвийн хөрөнгөөр 238.4 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 12.4 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 254.4 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 149.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.Акталсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 17.8 сая төгрөгөөр буурсан.Төсвийн хөрөнгөөр 30.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, бусад эх үүсвэрээр нийт 21.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.Акталсан болон шилжүүлсэн үндсэн хөрөнгө байхгүй байна.Үндсэн хөрөнгөд 101.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 17.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2483.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2483.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж төсвийн төслийн саналаас 264.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 2747.9 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна.Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2486.4 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 226.3 сая сая төгрөгийг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 4.4 сая төгрөгийн санхүүжүүлэхээр нийт 2747.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2486.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 224.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2.5 сая төгрөгийн орлогыг оруулсан байна.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2610.2 сая төгрөг буюу 95.0 хувьтай, дансанд 133.8 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	4,571.30	4,571.30	0.00	100.00
80312	Сургалт семинар	2,285.60	1,957.90	327.70	85.66
81605	Эрүүл мэндийг дэмжих	5099.6	3176.0	1,923.60	62.28
81801	Үдийн цай хөтөлбөр	104,131.40	90,989.10	13,142.30	87.38
81806	Дотуур байрны үйлчилгээ	235,315.90	188,710.50	46,605.40	80.19
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	51,403.00	51,393.40	9.60	99.98
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	12,759.00	11,297.80	1,461.20	88.55
81827	Бичиг үсгийн хөтөлбөр	19,320.00	17,328.60	1,991.40	89.69
81834	Боловсролын стандарт, сургалт	1,668,182.20	1,605,410.20	62,772.00	96.24
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	414,261.00	408,566.50	5,694.50	98.63
81848	Сурах бичгийн түрээс	4,272.80	2,483.80	1,789.00	58.13
71802	Ерөнхий боловсрол	226,313.00	224,353.60	1,959.40	99.13
	Дүн	2,747,914.80	2,610,238.70	3,779.90	94.99

Орон нутгаас санхүүжих ерөнхий боловсрол хөтөлбөрөөс 0.02 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Оны эцэст зарцуулагдаагүй 133.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 238.4 сая төгрөгийн бараа материал, 30.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2684.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 26.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2163.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 21.6 сая төгрөг болж байна.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 102.8 сая төгрөгийн 8 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2428.7 сая төгрөгийн 62 гүйлгээг, төсөв, мөнгө, хөрөнгөтэй холбоотой 38.5 сая төгрөгийн 38 шийдвэрийг хугацаа хоцроож оруулсан байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 90.6 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн.Аудитаар уулзалт хийж, байгууллагын талаар мэдээлэл, дотоод аудитын талаар мэдээлэл авч, холбогдох ажлын баримтуудыг цуглуулсан. Нөлөөллийн мэдүүлгийн баримтыг танилцуулж, гарын үсэг зуруулж, уулзалтын тэмдэглэлийг баримтжуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлуулаагүй, Алтай сумын Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 58 тоот захирамжийг үндэслэж Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 08304-2019/00006 дугаар гэрээгээр 40212 м/кв газрыг 30 жилийн хугацаатай эзэмшүүлэх гэрээ хийсэн боловч данс бүртгэлд үнэлж тусгаагүй байсанд,

Оны эцэст цалингийн зардлын төсвөөс 24.0 сая төгрөгийг хэмнэж улсын төсвийн санхүүжилтээс 30.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан боловч тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс 11.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй гарсанд,

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 8.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан 8 тушаал шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75 хувьтай байсан зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Дээрх зөвлөмжийн мөрөөр өгсөн зөвлөмжийг биелүүлэн, зөрчлийг арилган ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	4	26626.4	1	26626.4	100%
Нийт дүн	4	26626.4	1	26626.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлалтаас цалин олголт, цалин тогтоолтыг бүрэн шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар цалинг үнэн зөв олгосон эсэхийг дахин шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,470.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 20,470.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа. *Залруулсан алдаа:*

- Гранд Ай Ти компанид багшийн цахим систем худалдан авахаар шилжүүлсэн 10070.0 мянган төгрөгийг авлагаар тусгасныг урьдчилж гарсан зардлаар тусган залруулсан.
- Монголын цахилгаан холбоо компанид тоног төхөөрөмжийн үнийн урьдчилгаанд шилжүүлсэн 10400.0 мянган төгрөгийг зардлаар тусгасныг залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 5,015.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 143,363.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1.1.Илрүүлэлт:

1.Сургуулийн дотуур байрны багш Х.Жакед албан тушаалын ангилал зэрэглэл, орон тооны жишиг нормативт тусгагдаагүй дотуур байрны эрхлэгч гэсэн албан тушаалаар жилийн турш ТҮБД-4 шатлалаар цалинжуулж, нийт 2055.1 мянган төгрөгийн цалинг илүү олгосон зөрчил илэрлээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дүгээр тушаалаар баталсан “Орон тооны жишиг норматив батлах тухай” журам, Засгийн газрын 2019 оны 25 дугаар “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийн шинэчлэн тогтоох тухай” тогтоол, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 4 сарын 01-ний өдрийн А/122 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны 241 дүгээр “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16.5.5”д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтад нийцэхгүй байна.

2. Сургууль нь орон тооны жишиг нормативт тусгагдаагүй байхад захирлын 2023 оны 10 сарын 06 өдрөөрх тушаалаар няравын орон тоог шинээр бий болгож, 3 сарын туршид нийт 2959.9 мянган төгрөгийн цалинг олгосон байна.

Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дүгээр тушаалаар баталсан “Орон тооны жишиг норматив батлах тухай” журам, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16.5.5”д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитаар 143,363.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Батлагдсан орон тоог Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дугаар тушаалаар баталсан орон тооны жишиг нормативтай харьцуулж үзэхэд 7 орон тоог илүү ажиллуулж, төсвөөс 40561.7 мянган төгрөгийн зардал гаргасан.

Хүснэгт 5 /төгрөгөөр/

д/д	Ажиллах албан тушаал	Орон тооны жишгээр	ажиллаж байгаа орон тоо	илүү орон тоо	жилийн дүнгээр авсан дүн /төгрөгөөр/
1	Хичээлийн зохицуулагч	0	1	-1	650,976.24
2	Нярав /эд хөрөнгө хариуцсан ажилтан, агуулахын нярав/	1	2	-1	2,959,880.00

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Дотоод хяналт хариуцсан ажилтан	0	1	-1	11,947,095.56
4	Дотуур байрны жижүүр	4	5	-1	
5	Цагаан хэрэглэл угаагч	0	1	-1	8,675,485.58
6	Сав угаагч	0	1	-1	8,104,662.40
7	Бэлтгэгч	0	1	-1	8,223,773.49
Нийт дүн		5	12	-7	40,561,873.27

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дугаар тушаалаар баталсан "Орон тооны жишиг норматив батлах тухай" гэсэнтэй нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дугаар тушаалаар баталсан орон тооны жишиг нормативыг баримтлан ажиллах, илүү орон тооны асуудлыг цэгцлэх,

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зардлын 102.8 сая төгрөгийн 8 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 90.6 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4-т "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "мэдээллийг тогтмол шинэчилж байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4 дэх хэсгийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 7 дугаар зүйлийн 7.1-д "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ" гэсэн заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулаагүй 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зардлын 102.8 сая төгрөгийн 8 мөнгөн гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нөхөн байршуулан мэдээлж, зөрчлийг арилгах.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй	2	20,470.0	0	0	2	20,470.0	2	20,470.0				
Дүн	2	20,470.0	0	0	2	20,470.0	2	20,470.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн	3	45576,9					3	45576,9				
Дүн	3	45576,9					3	45576,9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсан мэдээлээгүй орхигдуулсан	1	102801.3					1	102801.3
Дүн	1	102801.3					1	102801.3

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит